

2023 оны 05 дугаар сарын 09 – ны өдөр

**Нүүр ам судлалын эмч /эмчилгээ, мэс засал, согог засал, гажиг засал,  
хүүхдийн нүүр ам судлал урьдчилан сэргийлэх/, шүдний техникч,  
нүүр амны эрүүл ахуйч мэргэжлээр мэргэшлийн зэрэг горилогчийн  
ТУСГАЙ ШААРДЛАГА**

### **АХЛАХ ЗЭРЭГ**

1. Тухайн мэргэжлээрээ үндсэн мэргэшил эзэмшсэн, үнэмлэхтэй байх / Нүүр амны техникч, нүүр амны эрүүл ахуйчид хамаарахгүй/
2. Мэргэжлийн чиглэлээр дотоод эсвэл гадаадын мэргэжлийн сургалтанд хамрагдсан байх. /гэрчилгээ, сертификат, батламжаар баталгаажина/
3. Мэргэжлийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцсон байх
4. Жил тутам биелүүлэх багц цагийн сургалтын 2/3 нь мэргэжлийн чиглэлээр, 1/3 нь халдвар хамгаалал, ёс зүй, яаралтай тусламжийн сургалтанд хамрагдсан байх
5. Нийгмийн хариуцлагын хүрээнд урьдчилан сэргийлэх үзлэгт оролцсон байх.

### **ТЭРГҮҮЛЭХ ЗЭРЭГ**

1. Тухайн мэргэжлээрээ үндсэн болон төрөлжсөн мэргэшил эзэмшсэн үнэмлэхтэй байх/ Нүүр амны техникч, нүүр амны эрүүл ахуйч хамаарахгүй/
2. Мэргэжлийн чиглэлээр дотоод эсвэл гадаадын мэргэжлийн сургалтанд хамрагдсан байх. /гэрчилгээ, сертификат, батламжаар баталгаажина/
3. Мэргэжлийн чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оролцсон байх
4. Жил тутам биелүүлэх багц цагийн сургалтын 2/3 нь мэргэжлийн чиглэлээр, 1/3 нь халдвар хамгаалал, ёс зүй, яаралтай тусламжийн сургалтанд хамрагдсан байх
5. Мэргэжлийн чиглэлээр дотоод эсвэл гадаадын мэргэжлийн сургалтанд хамрагдсан байх. /гэрчилгээ, сертификат, батламжаар баталгаажина/
6. Мэргэжлийн чиглэлээр судалгаа хийж олон улсын эсвэл дотоодын онол практик, эрдэм шинжилгээний хурлаар хэлэлцүүлсэн байх эсвэл анагаах ухааны мэргэжлийн хүлээн зөвшөөрөгдсөн гадаад эсвэл дотоодын хэвлэлд нийтлүүлсэн байх.
7. Мэргэжлийн чиглэлээр зөвлөгөө, шинжлэх ухаан- танин мэдэхүйн нийтлэл, шинэ мэдээлэл зэргийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хүргэсэн байх.

### **ЗӨВЛӨХ ЗЭРЭГ**

1. Тухайн мэргэжлээрээ үндсэн болон төрөлжсөн мэргэшил эзэмшсэн, үнэмлэхтэй байх / Нүүр амны техникч, нүүр амны эрүүл ахуйчид хамаарахгүй/
2. Мэргэжлийн тусламж үйлчилгээнд шинэ арга технологи нэвтрүүлсэн оюуны өмчийн гэрчилгээтэй эсвэл докторын зэрэг хамгаалсан бүтээл байх
3. Нүүр амны тусламж үйлчилгээ, мэргэжлийн чиглэлээр 3-с доошгүй судалгаа хийж олон улсын болон улсын хэмжээний онол практикийн бага хурлаар хэлэлцүүлсэн байх
4. Мэргэжлийн чиглэлээр олон улсын сургалтанд 3-аас доошгүй удаа хамрагдсан байх
5. Магистрын зэрэг хамгаалсан байх
6. Мэргэжлийн чиглэлээр гарын авлага, ном хэвлүүлсэн байх
7. Scopus-г бүртгэлтэй IF-тай сэтгүүлд 1 өгүүлэл хэвлүүлсэн байх.
8. Горилогч нь шаардлагын дагуу бүрдүүлсэн баримт бичиг, ажлын тайланг МШМХ-ны удирдах зөвлөлийн гишүүдийн хурлаар хэлэлцүүлж, зөвшөөрөл авсан байх.